

Хичээлийн судалгааны арга зүй “ЯПОНЫ САЙТАМА-2019” тайлан мэдээ



Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэгээс (МХСН) санаачлан зохион байгуулдаг “Хичээлийн судалгааны арга зүйн” ээлжит сургалт, аялал 2019 оны 05 дугаар сарын 27-ноос 06 дугаар сарын 03-ны хооронд Япон улсын Сайтама мужид амжилттай болж өндөрлөлөө.

Энэ удаагийн туршлага судлах аялалыг Сайтама их сургуулийн проф. Мацүзаки хариуцан зохион байгуулсан болно.

Проф. Мацүзаки Монголд 4 удаа ирсэн бөгөөд МХСН-ийн зөвлөхөөр ажиллаж байна.

Энэхүү сургалтын багт:



- Б.Хишигбаяр** МХСН-ийн Удирдах Зөвлөлийн тэргүүн,
О.Мягмаржав Нийслэлийн БЗД-ийн 14 дүгээр сургуулийн сургалтын менежер
Л.Баянтуул Нийслэлийн Амгалан ЦС-ийн захирал
Э.Бат-Эрдэнэ Ховд аймгийн боловсролын газрын мэргэжилтэн
Ч.Байгальмаа Ховд аймагийн 1 дүгээр сургуулийн менежер
Э.Ганжаргал Нийслэлийн Налайх дүүргийн ЭОЦС-ийн багш
Н.Мөнхтуул Нийслэлийн Налайх дүүргийн ЭОЦС-ийн багш
С.Ундрах Нийслэлийн БЗД-ийн 53 дугаар сургуулийн сургалтын менежер

- С.Гэрэлмаа** Нийслэлийн Багануур дүүргийн ГГЦС-ийн сургалтын менежер
Х.Мэндбаяр Нийслэлийн БГД 28 дугаар сургуулийн нийгмийн ажилтан
Ч.Чимгээ Нийслэлийн БЗД-ийн 33 дугаар сургуулийн сургалтын менежер
Х.Сарантуяа Нийслэлийн БЗД-ийн 33 дугаар сургуулийн нягтлан бодогч
Л.Должинсүрэн Нийслэлийн БГД 47 дугаар сургуулийн нийгмийн ажилтан
Г.Цэцэгмаа Ховд аймгийн Булган сумын сургуулийн захирал нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олон хамрагдлаа.

Бидний зорилго: Японы Сайтама мужийн Ерөнхий боловсролын төв, Сайтама их сургуулийн харьяа бага болон дунд сургуулийн үйл ажиллагаа, боловсролын системтэй танилцаж, хичээлийн судалгааны өдөрлөгт оролцон туршлага судлах



Бидний зорилт:

- Японы боловсролын системийн талаар ойлголттой болох
- Японы сургуулийн үйл ажиллагаатай танилцах
- Япон багш нарын багшлах арга зүйн туршлага судлах
- Японы багш нар арга зүйгээ хэрхэн дээшлүүлж байгаатай танилцах
- Хичээлийн судалгааны өдөрлөгт оролцох

Сайтама их сургуулийн харьяа дунд сургуулийн 8-р ангийн газар зүй, 9-р ангийн иргэний боловсрол судалгаат хичээлийн өдөрлөгт оролцож ажиглалт хийв.

2019-оны 05-28 нд



Япон орон:

Их Наран улс хэмээгдэн дэлхий дахинаа нэрлэгддэг арлын Япон орон технологийн өндөр хөгжил, түүхэн уламжлал, амьдралын хэв маягаар хэдийнээ дэлхийн бусад улс орнуудаас ялгаран хөгжлийн өндөр түвшинд хүрчээ. Хүн амын нягтрал 1м²-т оногдох тоо хэдийн 400 гарсан ч үнэхээр энэ улс, энэ хот тийм олон хүн амтай билүү гэж бодогдоход хүргэж байсныг нуух юун.



Зам харилцаа, нийтийн тээвэр дээд зэргээр хөгжсөн, үйлчилгээ нь чанартай хүртээмжтэй, эелдэг харилцаа, биесээ, өөрийгөө хүндэтгэн зорчих зорчигчид, хаа ч байхгүй хогийн савны эрэлд гарсан монголчууд, хогоо хаядаг гэдэг сэтгэхүйг хэзээч тархиндаа суулгаагүй япон иргэд.... Ийм хэв маяг дэг журамтай хүндлэл гэдгийг өөрийн эрхгүй мэдэрсэн сайхан улс гэдгийг нүдээр харж сэтгэл баясаж ирлээ. Бид өндөр хөгжилд хүрэхийн тулд юу хийх, яах ёстой вэ?, хаанаас юунаас эхлэх вэ. Дэлхийд гайхагддаг хамгийн хичээнгүй, тууштай, хөдөлмөрч ард түмнээс бид эхлээд юуг сурах, үлгэрлэх вэ гэж тэр улсад явах хугацаандаа бодож явлаа.

Сайтама их сургуулийн харьяа дунд сургуулийн Математикийн судалгаат хичээлийн өдөрлөгт оролцож ажиглалт хийв.

2019-05-29



8-р ангийн Геометрийн хичээл



9-р ангийн Магадлал статистикийн хичээл

Японы боловсрол:

Японы боловсролын хөтөлбөр нь 2-3 жил судалгаа хийж 10 жилээр төлөвлөн хийдэг, хэрэгжүүлдэг учир тогтвортой. Японы бүрэн дунд боловсрол ерөнхийдөө: Нэгдүгээр анхан шат Хоёрдугаар дунд шат Гуравдугаар гүнзгий шат гэсэн гурван үе шаттай аж. Нийтдээ 12 жил сурах хэрэгтэй байдаг ч зөвхөн 9-т нь заавал суралцах ёстой. Сурагчдын 94 хувь нь аравдугаар ангиа буюу ахлах сургуульд дэвшин суралцдаг бөгөөд энэ нь маш их зүтгэлийн дүнд бий болдог, онцгой үзүүлэлт юм. Гэхдээ бага сургуульд гэрийн даалгавар хийхгүй, хичээлийг дуусгах, хийж гүйцэтгэх шаардлагагүй мөн шалгалтад ач холбогдол өгөх шаардлагагүй гэсэн үндсэн зарчим үйлчилнэ.



гол зорилго нь сурагчдад ерөнхий суурь мэдлэг олгох болон цаашид судлах хичээлийн талаар ойлголт өгөхөд чиглэдэг байна. Тухайлбал, математик, байгалийн ухаан, хүн ба нийгэм, англи хэл, дуу хөгжим, уран ураг, физик зэрэг манай улсын дунд сургуулиудад үздэг хичээлүүд орно.

Японы боловсрол:

Мөн суурь хичээл болох эх хэлийг зөвхөн орчин үеийн төдийгүй эртний болоод дундад зууны япон хэлийг ч заадаг байна. Дөрөвдүгээр сар нь амьдралын нэгэн шинэ хуудсыг эхлүүлэхэд хамгийн тохиромжтой цаг үе буюу хичээлийн шинэ жил эхэлж, ирэх жилийн 3 сард дуусдаг.



Бага сургуулийн дүрэмд заасанчлан нэг хичээл 45 минут ба өдөрт дөрвөөс дээшгүй хичээл орно. Харин дунд сургууль нь өдөрт 6 цаг ба 50 минут.

Бусад орнуудын адил Японы сурагчид дүрэмт хувцастай боловч бага сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчид нь дүрэмт хувцас өмсдөггүй.

Хичээлийн хэлэлцүүлэг



Судалгаат хичээлийн дараа хэлэлцүүлгийн эхэнд 1. Японы сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, сургуулийн зорилго, хичээлийн судалгааны зорилго, сэдвийн талаар танилцуулга хийв. 2. Хэлэлцүүлгийг чиглүүлэгч тухайн хичээлийн судалгааны зорилго, хэлэлцүүлгийн дэгийг танилцуулав. 3. Хичээл заасан багш яагаад энэ сэдвээр хичээлийн судалгаа хийсэн зорилго, хичээлийн явц, дүгнэлтээ танилцуулна 4. Ажигласан багш нар санаагаа хэлнэ /давхцуулахгүй/ 5. Зөвлөх багш дүгнэж, зөвлөгөө өглөө.

Сайтама их сургуулийн харьяа бага сургуулийн Математикийн судалгаат хичээлийн өдөрлөгт оролцож ажиглалт хийв. 2019.05.30



Японы их дээд сургуулиуд өөрийн харьяа бага, дунд, ахлах сургуультай бөгөөд Профессоруудын удирдлаган дор хичээлийн судалгаа тогтмол хийх бөгөөд оюутнууд мөн харьяа сургууль дээр дадлага хийх зэрэг байнгын хамтын ажиллагаатай.

Хичээл судалгааны өдөрлөг.

Сайтама их сургуулийн харьяа дунд сургууль дээр болсон хичээлийн судалгааны өдөрлөгт Японы бусад мужийн их дээд болон дунд сургуулиас ажиглагч, судлаач, багш нар ирж оролцдог ба энэхүү өдөрлөг нь багш нар арга зүйгээ сайжруулахад ихээхэн ач холбогдолтой ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломжийг олгодог байна. Энэ удаагийн хичээлийн судалгаа нь 2020 оноос хэрэгжиж эхлэх Японы шинэ сургалтын хөтөлбөрийн бэлтгэл хангах буюу дараах зорилготой, Үүнд:

- ✓ Сурагчдыг харилцан ярилцаж сургах
- ✓ Бие даан сургах
- ✓ Гүнзгийрүүлэн сургах



Багш сурагчдаа хүндэлдэг, тэдэнд цагаа харамгүй зориулдаг, тэдний алдааг зөвөөр тусгаж авдаг гээд бидэнд сурах зүйл маш их байлаа.

Сурагчид нь хичээлд оролцож байгаа, бие дааж ажиллаж байгаа, санаагаа илэрхийлж байгаа, судалгаа хийж байгаа байдал гээд маш олон чадваруудыг эзэмшсэн байгаа нь үнэхээр олон жилийн тогтвортой хөтөлбөр ийм л үр дүнтэй дээ гэж харагдаж байлаа.

Хичээл судалгааны өдөрлөг

Залуу багш нартайгаа ахмад багш нар нь хамтарч ажилладаг. Хичээл дээр нь сууж ажиглалт хийж байж зөвлөгөө өгдөг. Залуу багшид жилдээ 4 орчим удаа хичээлийн судалгаа хийхэд нь зөвлөгөө өгдөг. Хичээл зааж үзүүлдэг. /Арга зүй, хүүхдийн харилцаа, хэрэглэгдэхүүн/ Хичээлийн бэлтгэл судалгаанд зөвлөгөө өгнө. Өөрийн гарын авлагаа үзүүлдэг, гэх мэт бүхий л талаар дэмжлэг үзүүлнэ.



Хамтран төлөвлөгөө боловсруулдаг. Жишээ нь хүүхдэд ямар даалгавар өгөх гэж байгаа, ямар асуулт асуух гэж байгаа, хүүхэд юу гэж хариулах бол гэх мэт зүйлсийг асуудаг. Бусад багш нар дээрээ туршилт хийж болно. Академийн багш нар ажиглана. Хэлэлцүүлэг явагдана. Дараа нь зөвлөх багш нь ганцаараа үлдээд залуу багштайгаа хамтран засан сайжруулалтаа хийнэ. Урам өгнө. Эдгээр багш нар маань цагт баригддаггүй. Хэзээ ч туслахад бэлэн байдаг

Хичээлийн судалгааны арга зүй сургалтын дүгнэлт

- 2020 онд хэрэгжүүлж эхлэх Японы шинэ сургалтын хөтөлбөрийн зорилго:
 - Сурагчдыг харилцан ярилцаж сургах
 - Бие даан сургах
 - Гүнзгийрүүлэн сургах гэсэн

3 зорилгыг гол болгож багш нар арга зүйгээ сайжруулах, харилцан бие биенээсээ суралцах, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих зорилгоор ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА хийж байна.

- Япон улсын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл арван жилээр төлөвлөгдөж хийдэг учир судалгаанд үндэслэсэн, тогтвортой, тасралтгүй хэрэгжсэнээр үр дүнд хүрдэг байна.
- 2020 оноос эхэлж хэрэгжих сургалтын хөтөлбөрийг 3 жилийн өмнө хэвлэж багш нарын гар дээр тарааснаар багш нар сайн судалж, хэрэгжүүлэх бэлтгэлийг сайн хангаж байна.
- Иймд 2019 онд бидний үзсэн судалгаат хичээл нь шинэ сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн шийдэл рүү чиглэсэн байлаа.
- Япон багш нар сурагчдаа хүндэлдэг, тэдэнд цагаа харамгүй зориулдаг, тэдний алдааг зөвөөр тусгаж авдаг, биеэ авч явах ёс журамд сургахад их анхаарч, суралцагчид өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөл боломж хандлагыг төлөвшүүлсэн.
- Сурагчийн гаргах алдаа нь багш нарт хичээлээ, арга зүйгээ сайжруулах маш том боломжийг олгодог. Иймд багш нар сурагчдыг алдсан гэж буруутгадаггүй, харин өөрийн ажилдаа дүгнэлт хийж, сайжруулах асуудлыг тодорхой болгодог.
- Шалгалт бол сайжруулах асуудлаа олж илрүүлэх гэсэн зарчимд суурилан явагддаг, шалгалтын дүнд шинжилгээ хийж сурагч яагаад алдав, түүнийг хэрхэн засах вэ, түүнд багш хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ, цаашид юуг анхаарах вэ гэдэгт хариулах зорилготой
- Хичээлийн судалгаа нь
 - Бэлтгэл судалгаа
 - Хичээл заах, ажиглах
 - Хичээлийн дараа хэлэлцүүлэг хийн сайжруулах асуудлыг дахин олж харна, энэ нь нэг хичээлээс дараагийн хичээл рүү сайжруулалт тасралтгүй хийгдэх үйл явц юм байна.
- Иймд Японы боловсролын нууц нь арга зүйгээ тасралтгүй сайжруулах боломжийг олгож байдаг Хичээлийн судалгаанд байдаг юм байна.

ТАЛАРХАЛ

Япон орны хөгжил, боловсролын давуу тал онцлогийг судлах боломж олгон хамтран ажилласан

- НБГ-ын орлогч дарга Ц.Отгончимэг,
- МХСН-ийн гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг,
- МХСН-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Хишигбаяр,
- БМДИ-ийн дэд захирал О.Оюунтунгалаг
- Сайтама их сургуулийн Проф. Мацүзаки нарт
- мөн Сургууль/Байгууллага хамт олондоо “САЙТАМА-2019” багийн хамт олон баярлаж талархаж байгаагаа илэрхийлье.



Сайтама түүхийн музей

2019.05.31



Орон нутгийн түүхийн музей муж, аймаг бүрт байх бөгөөд Боловсролын хамгийн чухал хэрэглэгдэхүүн болж ашиглагддаг.

Сайтама мужийн Ерөнхий Боловсролын төвийн үйл ажиллагаатай танилцлаа. 2019.05.31



Ерөнхий боловсролын төв:

Багш нараа хөгжүүлдэг, багш нарын хөгжих боломж, судалгааны гол цөм болсон боловсролын төв нь 100 гаруй ажилтан ажиллагсадтай. 5 сургалтын төвтэй. Судлагдахуун бүрийн багш нарыг хөгжүүлэх тус бүрийн арга зүйч мэргэжилтэн, тусгай зориулалтын тоног төхөөрөмж бүхий кабинеттай. 7 хоног бүрт Сайтама хотын 280 гаруй бага дунд ахлах сургуулийн багш нарт сургалт судалгаа явуулдаг. Бүх төрлийн техник тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнтэй, сурах, хөгжих орчин нөхцөл бүрэн хангагдсан.



Ерөнхий боловсролын төвийн кабинетууд



Мэдээлэл технологийн кабинет



Биологийн кабинет



Физикийн кабинет



Технологийн кабинет



Химийн кабинет

Тоглоомийн өрөө, уулзалтын өрөө



Газар зүйн кабинет



Сургалтын танхим





Спорт танхим



Цайны газар

Боловсролын төвийн номын сан

